

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- MoneyGram** мөнгөн гуйвуулгын үйлчилгээ (цаашид “Үйлчилгээ” гэх) нь MoneyGram Payment Systems Inc (цаашид MoneyGram гэх) компанийн төлөөлөгчдийн сүлжээгээр дамжуулан хийгддэг. Харилцагч та тухайн нутаг дэвсгэр дэх MoneyGram-н үйлчилгээний нэгжүүдийн (Үйлчилгээний нэгж) байршил болон ажиллах цагийн хуваарийн талаар үнэ төлбөргүй лавлах утаснаас болон аль нэг төлөөлөгчийн байранд очиж мэдээлэл авах боломжтой.
- Мөнгө илгээх.** Нэг удаад болон нэг өдрийн дотор илгээх мөнгөний нийт дүнд зөвшөөрөгдсөн дээд хязгаар байх ба өөрийн гүйлгээний боломжит лимитийн талаар үйлчилгээний төлөөлөгчөөс лавлана. Хуульд заасан бол таны илгээсэн болон хүлээн авсан гүйлгээний мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдээллэнэ. Та дараах байдлаар шуурхай мөнгө илгээх боломжтой. Үүнд: (i) MoneyGram-н үйлчилгээний нэгжээр дамжуулан хувь хүн (хүлээн авагч)- рүү шилжүүлэх; (ii) АНУ-аас бусад орны компаниудын гаргасан гуравдагч талын дебит карт руу шилжүүлэх (картын дугаараар шилжүүлэх); (iii) банкны данс руу шилжүүлэх. Гүйлгээ хийгдэх үед илгээгч болон хүлээн авагч аль нэг талд MoneyGram-аас “данс” үүсгэхгүй. Таны MoneyGram-д өгсөн бүх мэдээлэл бүрэн гүйцэт бөгөөд үнэн зөв болохыг та үүгээр баталгаажуулж байгаа болно.. Энэхүү гүйлгээний баримт дахь “Хүлээн авах улс”-ыг Та нягталж, шалгах шаардлагатай. Та хэн нэгэн үл таних хүн рүү мөнгө шилжүүлэхээс зайлсхийнэ үү.
- Мөнгө хүлээн авах.** MoneyGram үйлчилгээний нэгжээс та мөнгө хүлээн авах улсын гүйлгээний валютын талаарх мэдээллийг авах боломжтой. Таны илгээсэн гүйлгээг болон мөнгөөр, замын чекээр, бэлэн мөнгөний чекээр хүлээн авах боломжтой ба хэрвээ илгээгч нь дансны дугаар эсвэл картын дугаараар мөнгө илгээх сонголтоор илгээсэн бол данс болон картандаа хүлээн авах боломжтой. Хүлээн авагчид олгосон эсвэл карт гаргагч болон данс байршиж буй банканд (цаашид “Санхүүгийн байгууллагууд” гэх) таны гүйлгээний мэдээлэл хүргэгдсэн тохиолдолд MoneyGram таны өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Тодорхой улс орон руу хийгдсэн гүйлгээ хойшлогдож болзошгүй байдаг ба MoneyGram үйлчилгээний нэгжийн ажиллах цагийн хуваарийн дагуу хүлээн авагч нь мөнгө хүлээн авна. Гүйлгээг илгээснээс хойш 90 хоног өнгөрсөн эсвэл картын/дансны дугаараар илгээгдсэн гүйлгээг холбогдох санхүүгийн байгууллага зөвшөөрөөгүй тохиолдлуудад Илгээгч тал мөнгийг буцаан авах эрхтэй. Илгээгч нь картын/дансны дугаараар мөнгө илгээсэн тохиолдолд холбогдох санхүүгийн байгууллага хэзээ гүйлгээг зөвшөөрч хүлээн авагч нь картандаа/дансандаа мөнгө хүлээн авахыг MoneyGram шийдвэрлэхгүй бөгөөд карт/данс руу мөнгө шилжүүлэх гүйлгээ хийгдсэнээс хойш MoneyGram нь илгээгчийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. MoneyGram-ын шимтгэлээс гадна санхүүгийн байгууллагууд нэмэлт шимтгэл авах эсвэл хүлээн авах гүйлгээний дүнгээс холбогдох шимтгэлийг хасч олгох зэргээр шимтгэл суутгах эрхтэй. Гүйлгээ хийгдэх үед илгээгч болон хүлээн авагч аль нэг талд MoneyGram-аас “данс” үүсгэхгүй.
- Баталгаажуулалт.** Гүйлгээг хүлээн авахад гүйлгээний нууц дугаар зайлшгүй шаардлагатай. Илгээгч нь гүйлгээ илгээсний дараа хүлээн авагчид гүйлгээний нууц дугаарыг мэдээлэх бөгөөд аливаа гуравдагч этгээдэд гүйлгээний мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.
- Валютын арилжаа.** Та гүйлгээ илгээх гэж буй MoneyGram үйлчилгээний нэгжээсээ гүйлгээний валютын ханшийн мэдээлэл болон хүлээн авагчийн улс эсвэл тодорхой үйлчилгээний нэгжид зөвшөөрөгдөх валютын төрлийн талаар мэдээлэл авах боломжтой. Валют арилжааны холбогдох үйлчилгээний шимтгэл авах MoneyGram эсвэл тухайн үйлчилгээний нэгжээс тогтоосон валют арилжааны ханшаар гүйлгээг хийж болно.. Харилцагчид мэдэгдсэн ханш болон MoneyGram эсвэл үйлчилгээний нэгжийн хүлээн авахад гарсан аливаа ханшийн зөрүү нь MoneyGram эсвэл үйлчилгээний нэгжид үлдэнэ. Энэхүү баримтан дээрх “Хүлээн авах дүн” талбар дахь мэдээлэл нь дараахаас бусад тохиолдлуудад тухайн улсад хүлээн авах мөнгөн дүнг илэрхийлнэ. Үүнд: (1) Гүйлгээ илгээгдсэнээс хойш 90 хоног өнгөрсөн; (2) хүлээн авах дүн ам.доллар эсвэл еврогоор илэрхийлэгдсэн боловч тухайн улс дахь үйлчилгээний нэгж нь мөнгийг хүлээн авагчид олгоходоо өөр валютад хөрвүүлэх. Энэ тохиолдолд гүйлгээний дүнг MoneyGram болон үйлчилгээний нэгжийн харьяалагдах орон нутгийн валютын ханшийн дагуу хөрвүүлэн хүлээн авагчид олгоно. Хэрэв валютын ханш нь хүлээн авагч мөнгөө хүлээн авах мөчид тодорхойлогддог бол валютын ханшинд тухайн улсын улс төр, эдийн засгийн болон бусад нөхцөл байдал нөлөөлж, ханш өөрчлөгдөж байдаг. Иймд, нэг улсад байрлах хэдий ч мөнгө хүлээн авах үйлчилгээний нэгжээс хамаарч өөр өөр ханш тогтоогдож болно. MoneyGram нь гүйлгээний дараах ямар нэгэн валютын хөрвүүлэгт оролцохгүй. Үүнээс гадна хэрвээ хүлээн авагч нь үйлчилгээний нэгжийн олгодог валютаас болон энэхүү баримт дээр дурдагдсан валютаас өөр валютаар хүлээн авах, дансаар хүлээн авах тохиолдолд хүлээн авах дансны валют нь баримтан дээрх валютаас өөр байх зэрэг тохиолдлуудад үйлчилгээний нэгж нь валют арилжааны шимтгэл авч болно. Тус валют арилжаа нь хүлээн авагч болон үйлчилгээний нэгжийн хооронд хийгдэж буй тусдаа гүйлгээ тул MoneyGram-н гүйлгээ биш юм.
- Буцаан олгох мэдээлэл.** Илгээгчийн өгсөн мэдээлэл нь буруу, зөрүүтэй байсан эсвэл данс/карт руу илгээсэн гүйлгээ нь санхүүгийн байгууллагаар зөвшөөрөгдсөн тохиолдолд гүйлгээг буцаан дуудах боломжгүй. Илгээгч нь баримтын доор дурдсан хаягаар MoneyGram руу и-мэйлээр эсвэл анх гүйлгээ илгээсэн үйлчилгээний нэгжид хүсэлт гаргах замаар илгээсэн гүйлгээг буцаах боломжтой. Гүйлгээг буцаах хүсэлт нь гүйлгээ илгээсэн баримтын эх хувиар баталгаажна. Гүйлгээ буцаах хүсэлтийг MoneyGram хянаж, баталгаажуулах бөгөөд хүсэлт гаргаснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. MoneyGram системээр дамжин хийгдсэн гүйлгээнд зориулагдсан MoneyGram-н сан нь гүйлгээ дамжуулах зорилгоор ашиглагддаг бөгөөд “данс” биш юм.
- Хүчинтэй хугацаа.** Энэхүү баримтан дээрх хүлээн авах дүн нь гүйлгээ илгээсэн өдрөөс хойш 90 хоногийн дотор баримтан дээрх хүлээн авах улсад хүлээж авах боломжтой байна. 90 хоног өнгөрсний дараа гүйлгээг зөвхөн мөнгө илгээгч буцаан авах боломжтой болно. Гүйлгээ нь 90 хоногийн дараа олгогдох тохиолдолд валютын ханш нь мөнгө олгох үеийн MoneyGram болон үйлчилгээний нэгжийн тогтоосон ханшаар тодорхойлогдоно. Хэрвээ хүлээн авах дүн нь ам.доллар болон хүлээн авагч улсын үндэсний валютаар аль альнаар нь илэрхийлэгдсэн тохиолдолд ам.доллараарх дүнг хүчинтэйд тооцно. Учир нь хүлээн авах улсын валютаар илэрхийлэгдсэн дүн нь урьдчилан тооцоолсон ойролцоо дүн юм.
- Хугацаа хэтэрсэн гүйлгээ.** Хэрэв та гүйлгээг бэлнээр хүлээн авахаар илгээсэн бөгөөд хүлээн авагч нь уг гүйлгээг 90 хоногийн дотор аваагүй тохиолдолд тус гүйлгээ хүчингүй болно (хугацаа хэтэрсэн гүйлгээ). Гүйлгээ илгээснээс хойш 90 хоногийн дараагаас MoneyGram нь хугацаа хэтэрсэн гүйлгээг олгох боломжгүй. Хэрвээ таны гүйлгээ хугацаа хэтэрсэн гүйлгээ болсон тохиолдолд уг гүйлгээний дүнгээр буцаан авах эрхтэй. Хэрэв таны илгээсэн гүйлгээг хүлээн авагч нь аваагүй гэдгийг та мэдвэл MoneyGram-тай холбогдон гүйлгээг буцаан авна уу.
- Хариуцлага.** Хуулинд өөрөөр заагаагүй бол MoneyGram болон түүний төлөөлөгчдийн буруу, алдаатай үйлдлийн улмаас үүссэнээс бусад хугацаа хойшлогдсон, хүлээн авагч аваагүй, төлөгдөөгүй болон дутуу төлөгдсөн мөнгөн гуйвуулга, мөн гүйлгээний үндсэн дүн болон зохих шимтгэлийн дүнгээс илүү дүнгээр шимтгэл хураамж авсан нөхцөлд MoneyGram хариуцлага хүлээхгүй. Тухайн орон нутгийн зохицуулалтын дагуу, цаашлаад MoneyGram-н хяналтад нөлөөлөхүйц учир шалтгааны улмаас гүйлгээ саатах, хойшлогдох, өөрчлөгдөх тохиолдолд мөн MoneyGram хариуцлага хүлээхгүй. MoneyGram нь ямархуаа нэгэн тохиолдлын, шууд бус, тусгай эсвэл улбаалсан хохиролд мөн хариуцлага хүлээхгүй.
- 10.1 MoneyGram нь таны хувийн мэдээллийг хамгаалдаг. Иймд, MoneyGram таны хувийн мэдээлэл болон гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг танд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулах (одоогийн үйлчилгээг хянах) болон хуулиар зөвшөөрөгдсөн зах зээлийн судалгааны зорилгоор ашиглаж, мэдээллийн баазад хадгална.
- 10.2 MoneyGram нь таны дээрх мэдээлүүдийг өөрийн толгой компани болон бусад MoneyGram-н хамаарал бүхий компаниуд, үйлчилгээний нэгжүүд болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад дамжуулж болно. MoneyGram нь хуульд зааснаас бусад этгээдэд таны мэдээллийг дамжуулахгүй. Таны хувийн мэдээлэлд хандах хандалтыг хязгаарлах, аюулгүй байдлыг хангах бодлого, журмыг MoneyGram баримтална.
- 10.3 Хэрэв та өөрийн хувийн мэдээлэлд хандах, түүнийг шинэчлэх, засварлуулах эсвэл хууль ёсны шаардлагаар таны мэдээллийг ашиглахыг зөвшөөрөхгүй байгаа бол MoneyGram-д и-мэйлээр эсвэл лавлах төвтэй холбогдож хүсэлт гаргах боломжтой.
- 10.4 Уг гүйлгээг үргэлжлүүлснээр та [www.moneygram.com](http://www.moneygram.com) цахим хуудсан дээрх Нууцлалын мэдэгдэлд заасны дагуу таны хувийн мэдээллийг бүртгэх, ашиглах, мэдэгдэх болон дамжуулахыг (улс хоорондын шилжүүлэг мөн хамрагдана) MoneyGram-д зөвшөөрч байна.
11. **Үндсэн хэл.** Энэхүү үйлчилгээний нөхцөл нь Англи хэл дээр ыболовсруулагдаж, хэрэгжих бөгөөд аливаа тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтална. Англи хэлээс өөр хэл дээр орчуулсан хувилбар нь зөвхөн талуудын хэрэгцээнд зориулагдсан болно.

Холбоо барих, санал хүсэлт хүлээн авах:  
[www.moneygram.com](http://www.moneygram.com) цахим хуудсаар зочлон онлайн маягт бөглөх;  
[customerservice@moneygram.com](mailto:customerservice@moneygram.com) хаяг руу и-мэйл илгээх;  
MoneyGram, Konstruktorska Business Centre,  
13 Konstruktorska Street, Warsaw, Poland 02-673. хаягаар шуудан илгээх.